



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/01

Баянгол

Газар эзэмшүүлэх тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалтыг үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Хаан банкны барилгад үйлчилгээний зориулалтаар 510 м² газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.
2. Аж ахуйн нэгжтэй газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээжүүлэхийг газрын даамал /Б.Гэрэлт-Од/-д даалгасугай.
3. Гэрээний үүргийн хэрэгжилтийг ханган ажиллахыг газар эзэмшигчид үүрэг болгосугай.
4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2011 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/02 дугаар захирамжийн 1 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  М.ТУНГАЛАГТАМИР

C/barimt/Zahiramj/2018

00700001



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/02

Баянгол

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.3 дахь заалт, Аймгийн засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/363 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сургуулийн дотуур байрны сурагчдын хоол хүнс болон үдийн цайны хүнсний бүтээгдэхүүн, Цэцэрлэгийн хүүхдийн хоол цайны бүтээгдэхүүн нийлүүлэх тендер шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Н.Гэрэлмаа /Санхүүгийн албаны дарга/

Нарийн бичгийн дарга: Д.Ончимэг /ДАШБХ мэргэжилтэн/

Гишүүд: Д.Эрдэнэтуяа /Сургуулийн эмч/

Ө.Гансүх / Сургалтын менежер /

Д.Алтайбаатар /Сургууль, цэцэрлэгийн ня-бо /

Б.Отгончимэг /Цэцэрлэгийн багш/

Б.Мөнхчимэг / Эцэг эхийн төлөөлөл/

В.Оролмаа /Цэцэрлэгийн нярав/

Б.Ариунаа /Сургуулийн нярав /

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу ил тод, нээлттэй шалгаруулж, зохион байгуулахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА М.ТУНГАЛАГТАМИР



C/barimt/Zahiramj/2018

00700003



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 18 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/03

Баянгол

┌ Ажлын хэсэг байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Нийгмийн халамжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны 03 сарын 21-ний өдрийн А\32 дугаар тушаалаар батлагдсан “Хүнсний эрхийн бичиг олгох журам”-ын 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны үр дүнгээр хүнсний эрхийн бичиг авах эрх үүссэн өрхүүдэд хүнсний зүйл нийлүүлэх дэлгүүрийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Р.Оюунчимэг /ЗДТГ-ын дарга/

Гишүүд: Г.Өлзийсайхан /Халамжийн мэргэжилтэн/

Г.Ган-Очир /Баянгол багийн засаг дарга/

Ч.Нарантуяа /АДЗ-ийн гишүүн/

О.Зэнээзэг /ИТХ-ын төлөөлөгч/

2. Журмын дагуу сонгон шалгаруулалтыг явуулж материалыг аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт хугацаанд нь хүргүүлэхийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  М.ТУНГАЛАГТАМИР



C/barimt/Zahiramj/2018

00700005



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/04

Баянгол

Үрчлэлт бүртгэх тухай

Гэр бүлийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.7 дахь заалтыг үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шарга сумын Сондуулт багийн иргэн Өөлд овогтой Доржийн Цэрэнсодном, Орос овогтой Намсрайн Нямсүрэн нарын хүсэлтийг үндэслэн тус сумын Сондуулт багийн иргэн Өөлд овогтой Болормаагийн Ууганбаярыг Өөлд овогтой Доржийн Цэрэнсодномд үрчлүүлэхийг хүлээн зөвшөөрсүгэй.

2. Холбогдох баримтыг бүрдүүлж аймгийн Оюуны өмч, Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэл мэдээллийн тасагт хүргүүлэхийг Улсын бүртгэгч /Г.Гантулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР

C/barimt/Zahiramj/2018

00700007



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/05

Баянгол

Г Гэрээ байгуулах эрх олгох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт, Аймгийн Засаг даргын 2017 оны А/363 дугаар захирамж, Үнэлгээний хорооны 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тусгай зориулалтын санхүүжилтийн хөрөнгөөр хийгдэх “12 жилийн сургуульд хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх” ажилд “Дүүрэн Шарга” ХХК, “Их бор нуруу” ХХК, “Говийн ургац” нөхөрлөлтэй гэрээ байгуулах эрхийг 12 жилийн сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Золбаяр/-д, Цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх ажилд “Дүүрэн Шарга” ХХК, “Их бор нуруу” ХХК, “Чацарганатын гол” ХХК-тай гэрээ байгуулах эрхийг хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч /Н.Ариунбаяр/-д тус тус олгосугай.

2. Гэрээг 2018 оны 02 дугаар сарын 01-ээс 5 дугаар сарын 01 хүртэлх хугацаатай байгуулж, гүйцэтгэлийг хангуулж, захиалагчийн хяналтыг журмын дагуу тавьж ажиллахыг 12 жилийн сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Золбаяр/, цэцэрлэгийн эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч /Н.Ариунбаяр/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

М.ТУНГАЛАГТАМИР

C/barimt/Zahiramj/2018

00700009



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/06

Баянгол

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал аж ахуйн өвөлжилт хүндэрч байгаатай холбоотой нөхцөл байдалтай танилцах, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор багуудад ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хамтын хүч багт:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Мандах /ИТХ-ын дарга/

Гишүүд: Ж.Эрдэнэпүрэв /Багийн Засаг дарга/

Б.Гансэлэм /Багийн эмч/

Ш.Нямсүрэн /Жолооч/

Х.Төртулга /Засаг даргын орлогч/

Улаантуг, Сондуулт багт:

Ажлын хэсгийн ахлагч: М.Тунгалагтамир /Засаг дарга/

Гишүүд: Б.Гантулга /Багийн Засаг дарга/

Ц.Даваадорж /Багийн Засаг дарга/

Б.Гантулга /МЭҮТ-ийн мэргэжилтэн/

Ж.Хишигжаргал /Их эмч/

2. Багуудад ажиллах албан хаагчийн машин техникийн бүрэн бүтэн байдлыг хангуулахыг хэсгийн төлөөлөгч /П.Ууганбаатар/-т даалгасугай.

3. Шаардлагатай эм бэлдмэлийн нөөц бүрдүүлэхийг эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч /С.Цогзолмаа/-д үүрэг болгосугай.

4. Шатахуун тослох материалын хангалтыг бүрдүүлж ажиллахыг тамгын газрын дарга /Р.Оюунчимэг/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

М.ТУНГАЛАГТАМИР



C/barimt/Zahiramj/2018

00700011



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/07

Баянгол

Аян өрнүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал аж ахуйн өвөлжилт хүндэрч байгаатай холбоотой малчдад туслах сайн үйлсийн хандивын аянг сумын албан байгууллага, аж ахуйн нэгжүүд өрнүүлсүгэй.

2. Баянгол багийг бүрэн дунд сургууль, Хамтын хүч багийг Засаг даргын Тамгын газар, Сондуулт багийг эрүүл мэндийн төв, Улаан туг багийг хүүхдийн цэцэрлэг, соёлын төв тус тус хариуцан харилцаа тогтоож сэтгэл санаа, эд материалын туслалцаа үзүүлж хамтран ажиллахыг байгууллагын удирдлагуудад даалгасугай.

3. Аяны талаар сумын веб хуудас болон мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллахыг ДАШБХ мэргэжилтэн /Д.Ончимэг/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  М.ТУНГАЛАГТАМИР



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/08

Баянгол

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгууллагын архивт хадгалагдаж буй 1991-2017 оны мал тооллогын баримт бичгийн бүрэн бүтэн байдалд шалгалт, бүртгэл, тооллого хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Хорлоожав /Нийгмийн даатгалын байцаагч/

Д.Ончимэг /ДАШБХ мэргэжилтэн/

Б.Оюунтүлхүүр /Байгаль орчны байцаагч/

2. Тооллогыг 2018 оны 2 дугаар сарын 01-ний дотор хийж материалыг хугацаанд нь холбогдох газарт хүргүүлэхийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  М.ТУНГАЛАГТАМИР

